

УЛС ТӨР, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

**ӨВӨР МОНГОЛЫН ЗАСАГ ЗАХИРГААГ
НУТАГ ДЭВСГЭРИЙН ӨӨРЧЛӨЛТ
(1949—1983)****М. Зэнээ**

1949 оны 10-р сарын 1-нд БНХАУ-ыг тунхаглан байгуулсан үед ӨМӨЗО-ы харьяанд Хянган, Жирэм, Зуу-Уд, Шилийн гол, Цахар, Хөлөнбуйр зэрэг зургаан аймаг, 40 хошуу, 4 сян (хятад хошуу), 3 хот (Улаанхот, Хайлаар, Манжуур) орж байв. Энэ цагаас хойш Өвөр Монголын өөртөө засах орны засаг захиргааны байгууламж олон удаа өөрчлөгдсөн юм. Эхний үед хятад мужаас хэсэглэн тасалж Өвөр Монголд нэгтгэх ажил их хийгдэж байв. 1950 онд Баочан, Хуадэ, Долоннуур гэдэг гурван саяийг Цахар мужийн хамт ӨМӨЗО-д нэгтгэсэн ба 1954 онд Суйюань мужийг татан буулгаж ӨМӨЗО-д нийлүүлсэн нь засаг захиргааны нөлөө бүхий анхны томоохон өөрчлөлт болсон билээ.

1952 онд ӨМӨЗО-ы засаг захиргааны төв Цахарын Чуулалт хаалга хотоос нүүж одоогийн Хөх хотод (Гуйсуй-д) шилжин ирсэн¹ юм. 1953 онд ӨМӨЗО-ын засаг захиргааны «зүүн хэсгийн бүс» гэдгийг байгуулав. Энэ бүсд Хөлөнбуйр, Жирэм, Хянган аймаг болоод тэдгээрт харьяалагдах малжих ба тариалах хошуунууд мөн Тунляо, Улаанхот, Хайлаар, Манжуур зэрэг хот орж байв.

Энэ үед Их зуу аймгийн монгол үндэстний өөртөө засах район, Улаанцав аймгийн монголчуудын өөртөө засах районыг хуучин нэрээр нь Их зуу, Улаанцав аймаг хэмээн сэргээн нэрлэж ӨМӨЗО-д нэгтгэв. Үүний зэрэгцээ «Зүүн хэсгийн засаг захиргааны бүс» гэдгээ татан буулгаж Хянган, Хуна (Хөлөнбуйр) хоёр аймгийг нэгтгэн Хөлөнбуйр аймаг болгосон ба Жирэм аймгийг хэвээр нь сэргээн байгуулав. ӨМӨЗО-д шууд харьяалагдаж байсан Улаанхот, Хайлаар, Манжуур, Тунляо дөрвөн хотыг тус тусын аймгуудад нь харьяалах болов.

1955 онд Жэхэ (Халуун гол) мужид харьяалагдаж байсан Чжифэн (Улаанхад), Удан, Ниньчжэн хамээх гурван тариалах сян болон Харчин, Архан, Бинт гурван хошууг ӨМӨЗО-ы Зуу-Уд аймагт нэгтгэв.² 1956 онд Ганьсу мужийн Баянхотын монголчуудын өөртөө засах чжоу (тойрог) болон Эзний голын өөртөө засах хошууг ӨМӨЗО-д оруулан нэгтгэж Баяннуур аймаг³ болов. Алшаа хошууны төв Баян-хотыг Баяннуур аймагт захируулж Баян хот нэрээр үлдээв. 1958 онд Хэнтаогийн засаг захиргааг татан буулгаж Баяннуур аймагт нэгтгэсэн ба мөн Пиндицюаний засаг захиргааны нэгжийг татан буулгаж хойш нь Улаанцав аймагт нэгтгэв.⁴ Цахар аймгийг татан буулгаж

¹ Автономный район Внутренняя Монголия КНР. М., 1980, стр 76.

² Советская историческая энциклопедия. М., 1966., IX боть. с. 608.

³ Чжунго шаошу мэньцзю. Пекин. 1981, 69 - р тал.

⁴ « Жэньминь жибао » 1958. XI. 22

Шилийн гол аймагт нэгтгээд⁵ Баяннуур аймгийн Баян хотыг дахин татан буулгаж Алшаа хошуунд нь буцаан нэгтгэв. 1959 онд Баянгол хотыг байгуулж Баяннуур аймагт харьяалуулсан ба 1961 онд Баяннуур аймгийн Уда цайзыг (чжэнь) Уда хот хэмээн нэрлэж тус аймагт харьяалуулав. Мөн онд Их зуу аймагт хуучин харьяалагдаж байсан Хайбован хотыг Их зуу аймгийн харьяа хот болгов. 1962 онд Бээжингийн тойргийн Хэбэй мужийн Шаньду хошуу ӨМӨЗО-д нэгтгэв.

Үүнээс хойш гаднаас ӨМӨЗО-д нэгтгэх биш, харин ӨМӨЗО-оос гадагш нь тасалж багасгах аргад шилжин оров. 1964 онд Улаанхот, Баянгол хот хоёрыг татан буулгав. 1966 онд Эрээн боомтыг Эрлян (Эрээн) хот болгож Шилийн гол аймагт харьяалуулсан ба 1969 онд Хөлөнбуйр аймгийг ӨМӨЗО-оос салгаж Хармөрөн (Хэлунцзян) мужид нэгтгэв. Мөн онд Жирэм аймгийг татан буулгаж Гирин (Жийлэн) мужид, 1970 онд Зуу-Уд аймгийг татан буулгаж Ляонин мужид тус тус таслан нэгтгэв. Мөн тэр үед Баяннуур аймгийн Эзнээ хошуу ба Алшаа баруун хошууг Ганьсу мужид, Алшаа зүүн хошууг Ниньсягийн Хотон үндэстний өөртөө засах оронд тус тус ӨМӨЗО-оос салган нэгтгэв.⁶

1975 онд Их зуу аймгийн Хайбован, Баяннуур аймгийн Уда хот хоёрыг нэгтгэж Ухай хот болон өөрчлөн нэрлэв.

ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг тасчин хувааж, жижигрүүлэх эл бодлогын уршгаар 1960-аад оны эцсээс 1970-аад оны эхэн үед ӨМӨЗО-ы харьяанд Шилийн гол, Улаанцав, Их зуу, Баяннуур гэсэн дөрвөн аймаг, 5 хот, 16 сянь 27 хошуу багтах болж⁷ хуучнаасаа 2 аймаг, 13 хошуу 2 хотоор цөөрсөн байна.

Харин 1979 оноос гадагш таслан гаргасан аймаг хошуудаа ӨМӨЗО-д буцаан нэгтгэх болов. 1979 онд Ляонин мужийн Зуу-Уд аймаг, Гирин мужийн Жирэм аймаг болон Хорчин хошуу, Тучжуань сянь Хар мөрөн мужийн Хөлөнбуйр аймаг, Орчооны өөртөө засах хошуу, Морин даваа дагуур үндэстний өөртөө засах хошуу, Ганьсу мужийн Эзний хошуу, Алшаа баруун хошуу, Ниньсягийн Хотон угсаатны өөртөө засах орны Алшаа зүүн хошуу зэргийг ӨМӨЗО-ы харьяанд буцаан нэгтгэв.⁸ Мөн онд Алшаа аймгийг нэмж байгуулав. Энэ бүхний төгсгөлд ӨМӨЗО-ы шууд харьяа хотод Хөх хот, Бугат (Баотоу), Ухай гурав орж Улаанцав, Шилийн гол, Хөлөнбуйр, Зуун-Уд, Жирэм, Их зуу, Баяннуур, Алшаа зэрэг 8 аймаг харьяалагдах болов. Мөн 22 сянь, 53 хошуу, 3 өөртөө засах хошуу ӨМӨЗО-ы харьяанд багтдаг болжээ.⁹

1980 оны 7-р сарын 23-ны өдөр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн шийдвэр гарч Хянган аймгийг дахин сэргээн байгуулж түүний төв Улаан хот (Вангийн сүм)-ийг мөн сэргээв. Хянган аймгийн захиргаанд Хөлөнбуйр аймагт харьяалагдаж байсан Жалайд, Хорчин баруун газрын өмнөд хошуу, Тучжуань сянь болон мөн Жирэм аймагт харьяалагдаж байсан Хорчин баруун гарын дунд хошууг тус тус харьяалуулав. Ингээд Өвөр Монголын өөртөө засах орны харьяанд 9 аймаг 10 гаруй хот, 22 сянь, 54 хошуу, 3 өөртөө засах хошуу багтах болов.

⁵ Мөн тэнд.

⁶ «Жэньминь жибао». 1970. V. 25

⁷ Китай на стройке. Пекин. 1978, № 1, 42-р тал.

⁸ «Жэньминь жибао», 1979. VII. 21

⁹ Чжунхуа жэньминь гүнхэ го синьчжэнь цзюхуа цзяньцэ, Бээжин. 1980, 13-р тал.

1980 оны 9-р сарын 29-нд ӨМӨЗО-ы Намын Хороо, АТИХ-ын Байнгын хороо, Ардын засгийн ордноос Хянган аймгийн намын хороо, захиргаанд баярын цахилгаан илгээж түүндээ «БНХАУ-ын Төрийн Зөвлөлөөс Хянган аймгийн сэргээн байгуулахыг зөвшөөрсөн нь ӨМӨЗО-ы засаг захиргааны хуваарьт холбогдох томоохон үйл явдал боллоо. Энэ шийдвэр 10 жилийн самуурлын хорыг арилгах, үндэстнүүдийн бүлгэмдэл, нягтралыг сайжруулах, аж ахуй эдийн засгийг хөгжүүлэхэд чухал түлхэц болов» гэж тэмдэглэжээ. Дээрх баярын цахилгаанаас үзвэл ӨМӨЗО-ы засаг захиргаа, газар нутгийг олон арван жилийн турш ихэсгэж, багасгаж байсны буруу нь «соёлын хувьсгал»-ын хор нөлөө, бүр нарийвчлавал Линь Бяо «дөрвийн бүлгийн» үйл ажиллагаанаас болсон хэмээн одоо тайлбарлаж байна. Гэвч хэрэг дээрээ үүнээс ч нарийн, ноцтой бодлого, тухайлбал олон жил үргэлжилсэн Маогийн үндэстний бодлогын хор уршиг түүний цаана нуугдаж ирснийг мартаж аргагүй юм.

ӨМӨЗО-ы засаг захиргааны зохион байгуулалт өнгөрсөн 30 гаруй жид олон дахин хэсэглэгдэн өөрчлөгдсөөр ирснээс тоймтой цөөхөн хэдийг өгүүлэхэд ийм байна. Энэ олон удаагийн өөрчлөлтөөр хэзээнээсээ Өвөр Монголын үндсэн хэсэг, гол цөм нь байсаар ирсэн Цахар аймаг дотоод өөрчлөлтөнд бүрмөсөн бутарч алга болсон ажээ.

Хятадын маоист эрх баригчдын олон жил явуулсан хятад биш үндэстний өөртөө засан тохинох эрхийг бусниулан устгах хатуу зөөлөн арга нь өмнө өгүүлсэн тодорхой жишээгээр үзвэл юуны өмнө засаг захиргааны зохион байгуулалтыг эвдэх явдал байсан нь харагдаж байна. Өвөр Монголын өөртөө засах орны засаг захиргааны тогтсон хуваарийг дахин дахин эвдэн өөрчлөхдөө нэгтгэх, эсвэл хооронд нь холин хутгах, шинэчлэн байгуулах, татан буулгах нэрээр аажмаар алга болгох зэрэг олон аргыг хэрэглэж байсан юм.

ӨМӨЗО-ы засаг захиргааны нэгжүүдийг ингэж олон дахин холхиулан өөрчлөх нь монгол хүн амыг хятад хүн ам шигүү суудаг дотоод мужуудад газар нутгийн хамт таслан нэгтгээд тэр нутгийн уугуул монгол хүн амыг хятадын нутгийн гүн рүү дахин шилжүүлсний дараа уг нутагт ирж сууршсан олон түмэн хятадуудыг монгол нутгийн хамт буцаан ӨМӨЗО-д нэгтгэдэг болсон байна. Энэ арга нь ӨМӨЗО-д хятад хүний тоо туйлаас олон болж, монголчуудынхаа тооноос нэгэнт найм дахин илүү болоод цаашдид богино хугацааны дотор нэн их болж хэт давамгайлан ижилсүүлж уусах бүх нөхцөлийг нэгэнт бүрдүүлжээ.

Өнгөрсөн 30 гаруй жилд ӨМӨЗО-ы засаг захиргааны хуваарийг өөрчилсөн өөрчлөлт өмнө товч өгүүлснээр дуусаагүй юм. 1983 оны 2-р сарын эхээр ӨМӨЗО-ы төв Хөх хотод хуралдаж дууссан хошуу, сяний намын хорооны нарийн бичгийн дарга нарын хурлаар орон нутгийн нам, захиргааны анхан шатны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх шийдвэр гаргасан билээ. Бэлтгэл сайтай хийх энэхүү өөрчлөлтийн тэргүүн эгнээнд явахыг Өвөр Монгол дахь ХКН-ын хорооны 1-р нарийн бичгийн дарга Чжоу Хуй, орлогч дарга Бөхөө нар бүх сэхээтнүүдэд уриалснаас үзвэл зөвхөн боловсон хүчний төдийгүй, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд зохион байгуулалтын өөрчлөлт нэг биш удаа дахин давтагдана гэж үзэх үндэстэй байна. Үүний тодорхой жишээ бол 1983 оны 4-р улиралд ӨМӨЗО-д засаг захиргааны бас нэг том өөрчлөлт хийсэн явдал мөн. 1983 оны 10-р сарын 3-ны өдрөөс эхлэн БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн шийдвэрээр ӨМӨЗО-ы 9 аймгийн нэг болох Зуу-Уд аймгийг татан буулгаж Улаанхад хот хэмээн нэрлэж Өвөр Монголын өөртөө засах орны шууд харьяанд оруулав. Энэ өөрчлөлтөөр Зуун-Уд аймгийн харьяанд багтаж байсан

3 сян, 7 хошууг Улаанхад хотын харьяанд үлдээснээ зарлаж, ингэснээр өөртөө засах орны нэг том аймаг монголчуудын дунд эзлэх байр суурь, нөлөөгөөрөө хүчтэй суларчээ. Суларсны учир нь ӨМӨЗО-ы шууд харьяа хот болон хувиргаснаар нутгийн монголчуудын эзэн мэдэх эрх чөлөөг шууд хааж, бүх үйл ажиллагааг төвөөс шууд хянаж хариуцдаг боллоо гэсэн хэрэг юм. Ингэснээр Зуу-Уд аймгийн нутаг дэвсгэр дээр ямар үйлдвэр уурхай байгуулж, юуг нь ашиглах, хэнийг суулгах, хэнийг гаргах, хэн удирдах, тэрчлэн хятад хүмүүсийг хичнээн хэмжээгээр оруулж суурьшуулах бүх асуудал монголчуудын хувьд огт хамаагүй зүйл болон хувирч байгаа юм. Энэ өөрчлөлтийн эцэст ӨМӨЗО 8 аймагтай боллоо. Өөрчлөлтийн үед Шилийн гол аймгийн Авга нар хошууг татан буулгаж Шилийн хот болгосноор Шилийн гол аймаг 2 хот, 1 сян, 9 хошуутай боллоо. Их зуу аймгийн Дуншэнь сянийг татан буулгаж Дуншэнь хот болов. Хөлөнбуйр аймгийн Ботха хошууг Чжаланьтунь хот, Шугуйт хошууг Якиши хот болгон өөрчлөв.¹⁰ Ингэснээр Хөлөнбуйр аймаг 4 хот, 3 өөртөө засах хошуу, 6 хошуутай болж байна. 1983 оны эцсээр хийсэн энэ өөрчлөлт ӨМӨЗО-ы засаг захиргаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлт болсныг бид дээрх баримтаас харж байна. Энэхүү өөрчлөлтийн дүнд одоо ӨМӨЗО 8 аймагтай, 15 хоттой, аймгуудын харьяа 16 сян, хотын харьяа 4 сянтай, 51 хошуутай, 3 өөртөө засах хошуутай болоод байна.

Хятадын маоист эрх баригчид Өвөр Монголчуудын засаг захиргааны зохион байгуулалтыг зориудаар ингэж олон дахин эвдэн өөрчилсөн учир шалтгаан чухам юунд оршиж байсныг бид анхаарч үзэх хэрэгтэй. Юуны түрүүнд хятадын доторхи монголчуудын хүн ам, газар нутаг, нийгэм-соёлын амьдралыг бүхэлд нь хятадчилах зорилготой байв. Нөгөө талаар хятадын маоист эрх баригчид хөрш зэргэлдээ улс орнуудынхаа нутаг дэвсгэрт өнгөлзөхдөө хил хязгаарын хятад биш үндэстнүүдийн нутгийг цэрэг, дайны түшиц газар болох, энэ зорилгоо биелүүлэхийн тулд Өвөр Монголын засаг захиргааг өөрчилж уугуул монголчуудын эсэргүүцлийн нэгдмэл хүчийг сарниах, байгалийн баялгийг нь бүх талаар бүрэн дүүрэн ашиглах зэрэг хэд хэдэн тодорхой зорилго чиглэлтэй хийгдсээр ирсэн юм. Харин 1980-аад оны эхээс ӨМӨЗО-ы засаг захиргааны нэгжийг олшруулж, хуучин хятад мужуудад тараасан аймаг хошуудыг буцаан нэгтгэх ажил багагүй хийж эхэлсэн билээ. Энэ нь ч бас тодорхой зорилго чиглэлтэй байв. Учир нь одоогийн хятадын удирдлага ард түмний дотор байр сууриа бэхжүүлэх, дотоод гадаадад олон жил нэр хүндээ алдсан ХКН-ын нөлөөг сэргээх, хятад дахь монгол хүн амын эсэргүүцлийг намжаан зөөлрүүлэх, хятадын удирдлагын Өвөр Монголыг эрхшээл нөлөөндөө бүрэн барьж байх бодлогод хаашаа ч хөдлөх аргагүй болтлоо сарнин торлогдсон монголчуудын гомдол бухимдлыг түр зуур тайлах, урьд өмнө үндэстний талаар явуулсан харгис бодлогоо цагаатгах, Хятад орныг хүчирхэг гүрэн болгохын тулд Өвөр Монголын нутаг дэвсгэр, байгалийн баялагийг үндсэн бааз суурь болгон ашиглах гэсэн хэтийн зорилготой тактикийн үйл ажиллагаа болохыг үгүйсгэх хэрэггүй юм. Хятадын удирдлагын энэ мэт ажил явууллага сүүлийн үед хятадын дотоодод үйл явц таатай чиглэлээр өрнөж байна гэдэг сэтгэгдлийг гадаад дотоодод төрүүлэх гол зорилгыг агуулж байна. ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийн өөрчлөлт нь засаг захиргааны өөрчлөлттэй нягт холбоотой явагдаж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

¹⁰ «Жэньминь жибао». 1984. 1. 20

Мао Зэдун 1956 онд бичсэн «10 их харилцаа» гэдэгтээ хятад үндэстний «хүн ам олон» цөөн тоот үндэстний «газар уудам, эд баялаг элбэг байдаг»¹¹ гэж онцлон тэмдэглэж байсан юм. Маогийн энэ үг хятад биш угсааны газар нутаг, байгалийн баялагийг их хан (хятад) үндэстний мэдэлд бүрмөсөн барьж байх ёстой гэсэн томоохон дохио болсон билээ.

1947 оны 5-р сарын 1-нд ӨМӨЗО-ыг анх байгуулахад монголчуудын уугуул нутгийг бүхэлд нь хамраагүй юм. Тэр үед ӨМӨЗО-ы газар нутаг 500 мянган ам дөрвөлжин километр байлаа.¹²

БНХАУ байгуулагдсаны дараа 1949 оны XII сар нийтлүүлсэн засаг захиргааны хуваарьт ӨМӨЗО-ы нутаг дэвсгэр 700 мянган ам дөрвөлжин км гэж тэмдэглэсэн байв.

1950-иад оны сүүлийн мэдээгээр ӨМӨЗО-ы нутаг дэвсгэр 1 сая 400 мянга гаруй ам дөрвөлжин км¹³ болтлоо өргөжсөн бөгөөд энэ үед хятад хүн ам ихтэй хятадын засаг захиргааны нэгжүүдийг олон дахин ӨМӨЗО-ы харьяанд шилжүүлэн нэгтгэсэн билээ.

ӨМӨЗО-ы газар нутгийг тэлэх ажил 1958 он хүртэл тасралтгүй явагдаж байлаа. Энэ нь улс төрийн тодорхой зорилго агуулж байсныг хэлэх хэрэгтэй. Юуны өмнө Өвөр Монголын нутгийг БНМАУ-ын нутаг дэвсгэрийн хэмжээнд хүртэл өргөтгөх замаар БНМАУ-ыг Өвөр Монголоор дамжуулан өөртөө татах улмаар нэгтгэх гэсэн маогийнханы улс төрийн далд бодлоготой холбоотой байв. Гэвч маогийнхны энэ бодлого ямар ч амжилтанд хүрээгүй юм. Иймээс тэд бодлогоо өөрчилж 1958 оноос эхлэн « зохицуулах бодлого» гэгчид шилжин орсон юм. Энэ нь тэлэх өргөтгөх биш, монгол аймгуудыг өөр хооронд нь буюу хүн ам олонтой хятад хошуудад таслан нэгтгэх арга байв.

Өвөр Монгол хүн амын дотор уугуул нутагтаа эзэн эрхээ эдэлж, өөртөө засах тохинох гэсэн хөдөлгөөн ихэссэн нь Хятадын маоист эрх баригчидын бодлогод эрс харшилсан учир тэд дээрх аргыг сонгон авч хүчээр хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь монгол ба хятад үндэстний хоорондын зөрчлийг улам гүнзгийрүүлсэн юм. Үүнээс болж Өвөр Монголд «өөрөөр сэтгэгчдийн» эсрэг буюу «баруунтныг эсэргүүцэх» хөдөлгөөн гэгчийг 1957 онд өрнүүлж, олон мянган монголчуудыг «олон үндэстний эв нэгдлийг бусниулагчид», «улсаас урвагчид» хэмээн нэрлэж хүчтэй хэлмэгдүүлсэн билээ. Энэ хөдөлгөөний явцад ӨМӨЗО-оос 32 мянган хүнийг «биеийн хөдөлмөрөөр давтан хүмүүжүүлэхэд» албадан хөөсөн¹⁴ юм. Биеийн хөдөлмөрөөр давтан хүмүүжүүлэх гэдэг нь үнэндээ хятадын нутгийн гүн рүү насаар нь цөлөх арга байсан юм.

«Жэньминь жибао» сонины 1981 оны долдугаар сарын 14-ны өдрийн дугаарт олон жилийн турш ӨМӨЗО-ыг толгойлж байсан Улаанхүү «Үндэстний районыг автономичлах ялгуусан түүхэн явц» гэдэг том өгүүллийг хэвлүүлсэн юм. Уг өгүүлэлд «Үндэстний районыг автономичлох гэдэг нь улс орны нийт нутаг дэвсгэрээс салгахгүйгээр цөөн тоот үндэстэн бөөгнөрөн суугаа газарт үндэстний автономитыг хэрэгжүүлэх» явдал бөгөөд энэ нь олон үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх гэрэлт зам гэж номлоод «энэ замаас хазайх гэсэн аливаа оролдлого цөм бүтэшгүй» гэж тэмдэглэсэн нь хятадын орон нутгийн автономи гэгчийг хэрэгжүүлэхэд саад хийгчдийн эсрэг 1957 онд явуулсан «баруунт-

¹¹ «Хүнци» сэтгүүл. Пекин. 1977, № 1.

¹² «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүл. УБ., 1979, № 2, 79-р тал.

¹³ «Нэй мэнгү цзычжи цюй гайкуан» (ӨМӨЗО-ы товч тойм), Хөх хот 1962, 2-3-р тал.

¹⁴ Нэй мэнгү цзычжи цюй гайкуан. Хөх хот, 1962, 50-р тал.

ныг эсэргүүцэх хөдөлгөөн»-ийг нэг ёсондоо талархан зөвтгөсөн санаа болжээ.

«Аливаа үндэстнийг тухайн улсын хил хязгаарын дотор хүчээр барьж байхын эсрэг пролетари нар тэмцэхгүй байж чадахгүй бөгөөд энэ нь өөртөө засан тохинохын төлөө тэмцэл юм»¹⁵ гэж В. И. Ленин сургаж байсан билээ. Лениний энэ заалтыг амьдрал практик дээр ноцтой зөрчсөн хятадын удирдагчид өөрсдийгөө зөвтгөхийн тулд «Түүхийн хөгжлөөс болж манай үндэстний их гэр бүл Зөвлөлттэй адилгүй өөр хэлбэрийг сонгох хэрэгтэй болсон юм. Үндэстний орны өөртөө засахыг хэрэглэх нь...манайд бүрэн тохирох юм.»¹⁶ хэмээн тайлбарлаж В.И. Лениний заалтыг практик дээр шууд үгүйсгэсэн билээ. Хятад биш үндэстний ард түмэнд Бүгд Найрамдах Улсын эрх мэдэл олгохоос шууд татгалзсанаа Өвөр Монголын жишээн дээр хятадын удирдагчид тайлбарлахдаа: «ӨМӨЗО-ы нутаг дэвсгэр нь өргөн уудам боловч тэндэх монголчууд нь нийт монгол үндэстний хүн амын гуравны хоёр хувийг эзэлж байна. Үлдсэн нэг хувь нь хятад орноор тархан сууж байна» гээд тэдэнд цөмд нь өөртөө засах эрх олгосон мэтээр нотолж байв. Хятадын удирдагчдын олгосон өөртөө засах эрх гэдэг нь өөртөө засах тойрог (чжоу), өөртөө засах хошуу (сянь)-г хэлж байгаа бөгөөд энэ нь үндэстний өөртөө засан тохинох эрхийг «орон нутгийн олон шатны өөртөө засах» гэгч хоосон нэрээр орлуулан сольсон л хэрэг байв. Үүнийг өвөр монголын үндсэн хүн ам шийдвэртэй эсэргүүцэж байсан учир «соёлын хувьсгалын үед тэднийг бүр ч харгис хэрцгийгээр залхаан цээрлүүлсэн юм.

«Соёлын хувьсгалын» үед ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг дур мэдэн тасдан хуваах явдал урьд үзэгдээгүй их хэмжээгээр явагдав. Тэр үед ӨМӨЗО-ы нутгаас Хөлөнбуйрын 31 мянган ам дөрвөлжин км, Зуу-Уд аймгаас 170 мянган ам дөрвөлжин км нутаг зэрэг нийлбэр дүнгээр 670 мянган ам дөрвөлжин км нутаг тасдан авч зэргэлдээх хятад мужуудад хүчээр нэгтгэв. 1960-аад оны эцсээс 1970-аад оны дунд үе хүртэл ӨМӨЗО-ы харьяанд Шилийн гол, Улаанцав, Их зуу, Баяннуур гэсэн дөрвөн аймаг, 5 хот, 16 сянь, 27 хошуу багтаж нийт нутаг дэвсгэр нь 400 мянган ам дөрвөлжин км болтлоо¹⁷ багассан байна.

1979 онд Зуу-Уд, Жирэм, Хөлөнбуйр гурван аймаг болон Энээ, Алшаа зүүн ба баруун хошуу зэрэг 6 хошууг ӨМӨЗО-ы мэдэлд буцаан нэгтгэсний¹⁸ эцэст ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийн хэмжээ 1 сая 100 мянган ам дөрвөлжин км болсон ба зарим мэдээнд 1 сая 170 мянган ам дөрвөлжин нутагтай¹⁹ гэж тэмдэглэсэн байдаг. 1980 оны дундуур Хянган аймгийг нэмж байгуулсны дараа ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийн хэмжээ 1 сая 200 мянга илүү ам дөрвөлжин км²⁰ болсон гэж хятадын хэвлэлд тэмдэглэжээ.

Хамгийн сүүлийн үеийн мэдээнээс үзвэл БНХАУ-ын ӨМӨЗО-ы газар нутаг 1 сая 280 мянга гаруй ам дөрвөлжин км нутаг дэвсгэртэй²¹ болсон бололтой. Энэ бүхнээс үзвэл ӨМӨЗО-ы нутаг дэвсгэр 1949 оныхоос 600 мянга шахам ам дөрвөлжин км-ээр одоо нэмэгдээд байгаа мэт боловч 1950-иад оны сүүлийн үеийнхээс нэлээд хэмжээгээр бага байна.

¹⁵ В. И. Ленин. Зохиолууд. 22-р боть. 153-р тал.

¹⁶ «Хүнцн» 1980, № 1, 13-р тал.

¹⁷ Чжунхуа жэньминь гунхэ го синьчжэнь цюхуа цзяньцэ. Пекин. 1977

¹⁸ «Жэньминь жибао» 1979. VII. 21,

¹⁹ «Англи-Монголын нийгэмлэгийн сэтгүүл» 1980. VI дэвтрийн

²⁰ Хятадын он дарааллын бичиг. Пекин-Шанхай. 1981. 43-р тал.

²¹ «Жэньминь жибао» 1983. XII. 16,

ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг өнгөрсөн хугацаанд ийнхүү олон удаа ихэсгэж, багасгаж өөрчилсөн бөгөөд 1979, 1980 онд явсан сүүлийн өөрчлөлтөөр ӨМӨЗО-ы нутаг нэлээд хэмжээгээр тэлж өргөжсөн юм. ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг тэлж өргөтгөснөө хятадын суртал нэвтрүүлэг хятад биш ард түмний талаар явуулж байгаа «энэрэнгүй ардчилсан» арга хэмжээ үндэстний автономитын талаархи намын бодлыг амьдралд хэрэгжүүлж байгаагийн тодорхой жишээ, олон үндэстний эв нэгдэл, үндэстний районы соёл, боловсрол, эдийн засгийн байгууламж, улс орны батлан хамгаалах хүчийг бэхжүүлэн зузаатгахад олсон их амжилт²² мэтээр сурталчилж байна.

Гэвч бодит байдал өөр зорилго чиглэлтэй байгааг анхаарахгүй байж болохгүй юм. Хятадын удирдагчид өнгөн дээрээ хятад дахь монголчуудын талаар сүүлийн үед нэлээд анхаарч байгаа мэт боловч үнэндээ тэдний бодол санаа, хэтийн зорилго нь монгол хүн амын эсэргүүцэл, дургүйцлийг намжаан зөөлрүүлж улмаар бослого хөдөлгөөн гаргахгүй болох, монгол хүн амын дунд ХКН болоод нам төрийн удирдлагын алдагдсан нэр хүндийг дээшлүүлэх, энэ зорилгоор урьд өмнө явуулж байсан зарим нэг хэтэрхий илт харгис бодлогыг буруутган, хэлмэгдэгчдийг цагаатгах, монгол угсаатны газар нутгийг цэрэг дайны түшиц газар болгох, байгалийн баялагийг нь бүх талаар ашиглах зэрэг дээр өгүүлсэн хэд хэдэн тодорхой чиглэл зорилгод бүрэн үйлчилсээр байна. Үүний тодорхой жишээ бол 1983 оны 6-р сарын 4-нд болсон бүх хятадын ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн (БХАУГЗЗ-ийн) 6 дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулган дээр Дэн Инчаогийн хэлсэн үг юм. Тэрээр «үндэстнүүдийн хооронд харилцаа улсын хувь заяатай холбоотой бөгөөд цөөнх үндэстнүүдийн ихэнх район хил хязгаараар оршдог учир үндэстний асуудлыг зөв шийдвэрлэх нь стратегийн хувьд их чухал» гээд «цөөнх үндэстнүүдийн байгалийн баялаг хан үндэстний техникийн бололцоог ашиглах явдал социалист хүчирхэг улс болоход хэрэглэгдэх стратегийн хэтийн чиг шугам»²³ гэсэн нь дээр өгүүлсэн бидний дүгнэлтийг баталж байна.

АДМИНИСТРАТИВНЫЕ И ТЕРРИТОРИАЛЬНЫЕ ПРЕОБРАЗОВАНИЯ ВО ВНУТРЕННЕЙ МОНГОЛИИ

(Резюме)

М. Зэнээ

Начиная со дня провозглашения КНР во Внутренней Монголии были проведены неоднократные административные и территориальные реформы. Суть этих реформ, а также, проводившейся на протяжении многих лет национальной политики маоистского руководства заключалась, во первых, в китаезации местного населения, его территории и всех сфер общественной и культурной жизни, во-вторых, в использовании пограничных районов Китая, заселенных нацменьшинствами, в качестве военно-стратегического плацдарма против соседних государств.

²² ИБАС, 1979. VII. 22. № 6611.

²³ «Жэньминь жибао» 1983.VI.5.

Неоднократно проводившиеся территориальные реформы во Внутренней Монголии вызвали недовольство и наталкивались на упорное сопротивление местного населения, которое стремилось сохранить в неприкосновенности свою исконную территорию и оградить от чужого влияния свою самобытную культуру.

Территориальные реформы во Внутренней Монголии уничтожали исторически сложившиеся границы аймаков, не принимая во внимание этнического состава проживающего там населения. Так, например, в результате реформ с карты Внутренней Монголии почти полностью исчезли Цахарский Джоу-удский и другие аймаки.

Начиная с периода «культурной революции», вплоть до начала 80-х годов территориальные реформы во Внутренней Монголии привели к раздробленности этого района, что облегчало контроль над монгольским населением со стороны китайского руководства.

В последнее время заметен и обратный процесс частичного «объединения» автономного района Внутренней Монголии, притом опять-таки не без тех или иных отступлений. Китайское руководство видит в этом проявление своего «гуманного демократизма» в отношении монгольского народа. На самом же деле эти мероприятия имеют целью смягчить недовольство монголов китайской администрацией, затушевать последствия реакционной политики прошлых лет, более беспрепятственно использовать полезные ископаемые и природные богатства Внутренней Монголии.

Территориальные и административные реформы, проводившиеся на протяжении многих лет в отношении основных территорий национальностей, были и остаются одним из методов и средством национальной политики китайского руководства, к которым оно прибегало исходя из целей центрального правительства и ханьцев. Интересы не китайских народов в Китае при этом полностью игнорировались. В связи с этим вполне вероятно, что такого рода территориальные и административные реформы во Внутренней Монголии, как и других автономных районах и в будущем будут продолжены.